БАЯНХОНГОР АЙМАГ ДАХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

---

Баянхонгор аймгийн Бөмбөгөр сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код: БНА-2025/012/НА-СТА-ТТЗ**

| | |
|---|---|
| Баянхонгор<br>2025 он<br>Цахим хуудас: www.audit.mn | Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат<br>Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn<br>Аудитын менежер: М.Алтантуяа<br>Утас: 80112188 Цахим хаяг: altantuyam@audit.gov.mn<br>Ахлах аудитор: Н.Батчимэг<br>Утас: 99049866 Цахим хаяг: batchimegn@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ ..... 7
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА ..... 15
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт ..... 16
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ..... 16
3.4 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд ..... 16
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга ..... 17
3.5.1. Мөнгөн хөрөнгө ..... 17
3.5.2 Авлага ..... 17
3.5.3 Бараа материал ..... 18
3.5.7 Үндсэн хөрөнгө ..... 19
3.5.8 Өр төлбөр ..... 20
3.5.9 Засгийн газрын хувь оролцоо ..... 20
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв ..... 21
3.7 Орлогын данс ..... 21
3.8 Зардлын данс ..... 22
3.9 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга ..... 23
АУДИТЫН ТАЙЛАН ..... 25
4.1. Ерөнхий зүйл ..... 25
4.2 Материаллаг байдал ..... 26
4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ..... 26
4.4 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт ..... 26
4.6 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ..... 27
4.7 Дараагийн аудитаар анхаарах асуудал ..... 27
4.8 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг ..... 27
4.9 Аудитын гол асуудал ..... 27
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ ..... 29
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ: ..... 31

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ЕБС | Ерөнхий боловсролын сургууль |
| ЗДТГ | Засаг даргын Тамгын газар |
| ИТХ | Иргэдийн Төлөөлөгчдийн хурал |
| НББББББ | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг |
| ОНХС | Орон нутгийн хөгжлийн сан |
| СТСХ | Санхүү, төрийн сангийн хэлтэс |
| ТЕЗ | Төсвийн ерөнхийлөн захирагч |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| ХХС | Хоршоо хөгжүүлэх сан |

**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584
Цахим шуудан:procurement. bayankhongor@audit.gov.mn

2025.03.25 № 2/106

танай_____________-ны № _____________ -т

БӨМБӨГӨР СУМЫН ЗАСАГ
ДАРГА Н.ПҮРЭВСҮРЭН ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-д заасны дагуу Баянхонгор аймгийн Бөмбөгөр сумын Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн нэгтгэсэн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Байгууллагын удирдлага нь санхүүгийн нэгтгэсэн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

8425020515

Тус сум нь 13 нэр төрлийн орлогоор 977,683.9 мянган төгрөг төвлөрүүлэхээс 1,216,381.3 төгрөгийг төвлөрүүлж, нийт орлого 124.4 хувь буюу 238,697.4 мянган төгрөгөөр давж биелсэн бөгөөд орлогын нэр төрлөөр авч үзвэл 9 нэр төрлийн орлого 338,897.0 мянган төгрөгөөр давж биелсэн, 4 нэр төрлийн орлого 100,217.6 мянган төгрөгөөр тасарсан байна.

**Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Сумын засаг дарга нь жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 9 зорилтын 95 арга, хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг аймгийн ЗДТГ-ын хяналт шинжилгээ үнэлгээний хэлтэс 87.6 хувиар үнэлсэн байна.

Тайлант онд хэрэгжүүлэх 9 зорилтын 95 арга хэмжээнд зориулан нийт 2,660,061.8 мянган төгрөгийг зарцуулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр нийт 2,048,059.0 мянган төгрөгийг зарцуулж, 77.0 хувийн биелэлттэй байна.

Бөмбөгөр сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцахад материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Сумын Засаг дарга санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн нэгтгэсэн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн нэгтгэсэн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн нэгтгэсэн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Б.МӨНХБАТ

ᠪᠠᠶᠠᠨᠬᠣᠩᠭᠣᠷ ᠠᠶᠢᠮᠠᠭ ᠲᠠᠬᠢ
ᠲᠥᠷᠦ ᠶᠢᠨ ᠠᠦ᠋ᠳᠢᠲ ᠤᠨ ᠭᠠᠵᠠᠷ

[illegible] 2024-04-[illegible] [illegible]

procurement.bayankhongor@audit.gov.mn
[illegible] : (976) 70442584
[illegible] · 64101
[illegible] 1 [illegible]
310 [illegible] 3

[illegible]

[illegible]

[illegible] 31 [illegible] 2024 [illegible] 12 [illegible] 31 [illegible]

[illegible] 8 [illegible] 8.9.3 [illegible] 2024 [illegible] 12

[illegible] 6 [illegible] 6.3.1 · 8 [illegible] 8.1 · [illegible]

00642502 0281

ᠰᠠᠩᠬᠦᠦ ᠶᠢᠨ ᠬᠢᠨᠠᠯᠲᠠ ᠪᠠᠷ ᠲᠠᠶᠢᠯᠠᠨ ᠤ ᠬᠤᠭᠤᠴᠠᠭᠠᠨ ᠳᠤ ᠲᠥᠰᠦᠪ ᠦᠨ ᠰᠠᠬᠢᠯᠭ᠎ᠠ ᠶᠢ ᠲᠤᠰᠬᠠᠨ ᠬᠢᠨᠠᠨ ᠰᠢᠯᠭᠠᠭᠰᠠᠨ ᠪᠠᠷ ᠨᠢ ᠰᠠᠩᠬᠦᠦ ᠶᠢᠨ ᠬᠦᠷᠢᠶᠡᠯᠡᠩ ᠪᠠᠶᠢᠨ᠎ᠠ ::

ᠰᠠᠷ᠎ᠠ ᠬᠣᠳᠣᠭᠰᠤ ᠨᠢ 13 ᠰᠠᠷ᠎ᠠ ᠬᠦᠷᠲᠡᠯᠡ ᠬᠤᠭᠤᠴᠠᠭ᠎ᠠ ᠳᠤ 977,683.9 ᠮᠢᠩᠭ᠎ᠠ ᠲᠥᠭᠦᠷᠢᠭ ᠦᠨ ᠲᠥᠯᠦᠪᠦᠷᠢ ᠶᠢ ᠲᠥᠯᠦᠭᠰᠡᠨ 1,216,381.3 ᠮᠢᠩᠭ᠎ᠠ ᠲᠥᠭᠦᠷᠢᠭ ᠨᠢ ᠲᠥᠯᠦᠪᠦᠷᠢ᠂ ᠡᠭᠦᠨ ᠡᠴᠡ 124.4 ᠲᠡᠷᠪᠡᠮ ᠪᠤᠶᠤ 238,697.4 ᠮᠢᠩᠭ᠎ᠠ ᠲᠥᠭᠦᠷᠢᠭ ᠢ ᠬᠣᠶᠢᠰᠢᠯᠠᠭᠤᠯᠤᠭᠰᠠᠨ ᠪᠠᠶᠢᠨ᠎ᠠ᠂ ᠡᠭᠦᠨ ᠡᠴᠡ 9 ᠰᠠᠷ᠎ᠠ ᠬᠦᠷᠲᠡᠯᠡ ᠬᠤᠭᠤᠴᠠᠭ᠎ᠠ ᠳᠤ 338,897.0 ᠮᠢᠩᠭ᠎ᠠ ᠲᠥᠭᠦᠷᠢᠭ᠂ 4 ᠰᠠᠷ᠎ᠠ ᠬᠦᠷᠲᠡᠯᠡ ᠬᠤᠭᠤᠴᠠᠭ᠎ᠠ ᠳᠤ 100,217.6 ᠮᠢᠩᠭ᠎ᠠ ᠲᠥᠭᠦᠷᠢᠭ ᠦᠨ ᠲᠥᠯᠦᠪᠦᠷᠢ ᠪᠠᠶᠢᠨ᠎ᠠ ::

**ᠲᠥᠰᠦᠪ ᠦᠨ ᠭᠦᠢᠴᠡᠳᠬᠡᠯ ᠦᠨ ᠠᠷᠭ᠎ᠠ**

ᠲᠥᠰᠦᠪ ᠦᠨ ᠭᠦᠢᠴᠡᠳᠬᠡᠯ ᠦᠨ ᠲᠠᠶᠢᠯᠤᠨ ᠳᠤ ᠬᠢᠨᠠᠯᠲᠠ ᠬᠢᠭᠰᠡᠨ ᠳᠦᠩ ᠢ ᠳᠤᠷᠠᠳᠤᠪᠠᠯ᠂ 2024 ᠣᠨ ᠤ ᠲᠥᠰᠦᠪ ᠦᠨ ᠵᠠᠷᠤᠯᠲᠠ ᠶᠢᠨ ᠭᠦᠢᠴᠡᠳᠬᠡᠯ 87.6 ᠬᠤᠪᠢ ᠲᠠᠢ ᠪᠠᠶᠢᠨ᠎ᠠ ::

ᠬᠥᠷᠦᠩᠭᠡ ᠣᠷᠣᠭᠤᠯᠤᠯᠲᠠ ᠶᠢᠨ 95 ᠲᠥᠰᠦᠯ᠂ ᠠᠷᠭ᠎ᠠ ᠬᠡᠮᠵᠢᠶ᠎ᠡ 9 ᠬᠡᠷᠡᠭᠵᠢᠭᠦᠯᠦᠭᠴᠢ ᠶᠢᠨ ᠨᠡᠶᠢᠲᠡ 2,660,061.8 ᠮᠢᠩᠭ᠎ᠠ ᠲᠥᠭᠦᠷᠢᠭ ᠦᠨ ᠲᠥᠰᠦᠪ ᠡᠴᠡ 2,048,059.0 ᠮᠢᠩᠭ᠎ᠠ ᠲᠥᠭᠦᠷᠢᠭ ᠢ ᠰᠠᠨᠬᠦᠦᠵᠢᠭᠦᠯᠵᠦ᠂ ᠭᠦᠢᠴᠡᠳᠬᠡᠯ 77.0 ᠬᠤᠪᠢ ᠲᠠᠢ ᠪᠠᠶᠢᠨ᠎ᠠ ::

**ᠨᠡᠶᠢᠰᠯᠡᠯ ᠦᠨ ᠲᠥᠰᠦᠪ ᠦᠨ ᠬᠥᠷᠦᠩᠭᠡ ᠣᠷᠣᠭᠤᠯᠤᠯᠲᠠ ᠶᠢᠨ ᠬᠡᠷᠡᠭᠵᠢᠯᠲᠡ᠂ ᠦᠷ᠎ᠡ ᠳ᠋ᠦᠩ**

ᠬᠥᠷᠦᠩᠭᠡ ᠣᠷᠣᠭᠤᠯᠤᠯᠲᠠ ᠶᠢᠨ ᠲᠥᠰᠦᠯ᠂ ᠠᠷᠭ᠎ᠠ ᠬᠡᠮᠵᠢᠶ᠎ᠡ ᠶᠢᠨ ᠭᠦᠢᠴᠡᠳᠬᠡᠯ᠂ ᠲᠥᠰᠦᠯ ᠢ ᠲᠥᠯᠥᠪᠯᠡᠬᠦ᠂ ᠡᠬᠢᠯᠡᠬᠦ᠂ ᠬᠦᠯᠢᠶᠡᠯᠭᠡᠨ ᠦᠭᠬᠦ ᠦᠶ᠎ᠡ ᠳᠦ ᠬᠢᠨᠠᠯᠲᠠ ᠬᠢᠵᠦ᠂ ᠬᠤᠤᠯᠢ ᠲᠣᠭᠲᠠᠭᠠᠮᠵᠢ ᠶᠢ ᠮᠥᠷᠳᠡᠭᠦᠯᠦᠭᠰᠡᠨ ᠡᠰᠡᠬᠦ ᠶᠢ ᠬᠢᠨᠠᠬᠤ ᠶᠢ ᠵᠣᠷᠢᠯᠠᠭᠠ :: ᠬᠥᠷᠦᠩᠭᠡ ᠣᠷᠣᠭᠤᠯᠤᠯᠲᠠ ᠶᠢᠨ ᠲᠥᠰᠦᠯ ᠨᠢ ᠲᠥᠯᠥᠪᠯᠡᠭᠳᠡᠭᠰᠡᠨ ᠬᠤᠭᠤᠴᠠᠭ᠎ᠠ ᠳᠤ ᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠤᠭᠳᠠᠵᠤ ᠴᠢᠨᠠᠷ ᠤᠨ ᠰᠢᠭᠠᠷᠳᠠᠯᠭ᠎ᠠ ᠢ ᠬᠠᠩᠭᠠᠵᠤ᠂ ᠠᠰᠢᠭ᠋ᠯᠠᠯᠲᠠ ᠳᠤ ᠣᠷᠣᠭᠤᠯᠤᠭᠰᠠᠨ ᠡᠰᠡᠬᠦ ᠶᠢ ᠬᠢᠨᠠᠭᠰᠠᠨ ::

**ᠰᠠᠩᠬᠦᠦ ᠶᠢᠨ ᠲᠠᠶᠢᠯᠤᠩ ᠤᠨ ᠬᠢᠨᠠᠯᠲᠠ ᠶᠢᠨ ᠳᠦᠩ᠂ ᠳᠦᠭᠨᠡᠯᠲᠡ**

ᠰᠠᠩᠬᠦᠦ ᠶᠢᠨ ᠲᠠᠶᠢᠯᠤᠩ ᠳᠤ ᠬᠢᠨᠠᠯᠲᠠ ᠬᠢᠭᠰᠡᠨ ᠳᠦᠩ ᠢ ᠦᠨᠳᠦᠰᠦᠯᠡᠨ ᠰᠠᠩᠬᠦᠦ ᠶᠢᠨ ᠲᠠᠶᠢᠯᠤᠩ ᠳᠤ ᠨᠢ ᠰᠠᠨᠠᠯ ᠳᠦᠭᠨᠡᠯᠲᠡ ᠭᠠᠷᠭᠠᠵᠤ᠂ ᠬᠠᠷᠢᠭᠤᠴᠠᠯᠲᠠ ᠶᠢᠨ ᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠯᠠᠭ᠎ᠠ ᠳᠤ ᠬᠦᠷᠭᠡᠭᠰᠡᠨ ᠪᠠᠶᠢᠨ᠎ᠠ ::

ᠲᠠᠶᠢᠯᠤᠩ ᠤᠨ ᠦᠨᠡᠨ ᠵᠥᠪ ᠢ ᠨᠤᠲᠠᠯᠠᠬᠤ ᠬᠦᠷᠲᠡᠯᠡ ᠰᠠᠩᠬᠦᠦ ᠶᠢᠨ ᠲᠠᠶᠢᠯᠤᠩ ᠢ ᠶᠡᠷᠦᠩᠬᠡᠢ ᠳᠦ ᠨᠢ ᠬᠠᠷᠢᠭᠤᠴᠠᠬᠤ ᠬᠠᠮᠢᠶ᠎ᠠ ᠪᠦᠬᠦᠢ ᠡᠷᠬᠡ ᠪᠦᠬᠦᠢ ᠬᠦᠮᠦᠨ ᠦ ᠲᠥᠯᠦᠭᠡᠯᠡᠭᠴᠢ ᠳᠦ ᠵᠥᠪᠯᠡᠮᠵᠢ ᠬᠦᠷᠭᠡᠬᠦ ᠭᠡᠵᠦ ᠲᠣᠭᠲᠠᠭᠠᠪᠠ ::

ᠬᠠᠪᠰᠤᠷᠤᠯᠲᠠ ᠑ ᠬᠠᠷᠢᠭᠤᠴᠠᠬᠤ ᠠᠵᠢᠯᠲᠠᠨ᠂ ᠬᠠᠷᠢᠭᠤᠴᠠᠭᠴᠢ ᠑᠐ ·· ᠭᠠᠷ ᠦᠰᠦᠭ᠂ ᠲᠠᠮᠠᠭ᠎ᠠ

## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан (мянган төгрөгөөр)

| Код | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,224,227.28** | **1,992,466.69** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | **344,395.51** | **1,020,788.48** |
| **31200** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | **344,395.51** | **1,020,788.48** |
| **31210** | **Төгрөг** | **344,395.51** | **1,020,788.48** |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 344,395.51 | 1,020,788.48 |
| **33** | **АВЛАГА** | **203,206.62** | **326,606.27** |
| 33300 | Татаас, санхүүжилтийн авлага | 0.00 | 106,960.07 |
| 33400 | Зээлийн хүүгийн авлага | 14,737.06 | 15,993.05 |
| **33500** | **Бусад авлага** | **58,187.83** | **58,912.18** |
| 33510 | Байгууллагаас авах авлага | 58,187.83 | 58,912.18 |
| **33600** | **Зээлийн авлага** | **130,281.74** | **144,740.98** |
| **33610** | **Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага** | **130,281.74** | **144,740.98** |
| 33612 | Хувь хүмүүст олгосон зээл | 15,781.80 | 6,385.57 |
| 33615 | Хувийн хэвшлийн аж ахуйн нэгжид олгосон зээл | 114,499.94 | 138,355.41 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **676,625.14** | **645,071.94** |
| **35100** | **Түүхий эд материал** | **7,457.33** | **4,811.02** |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 7,457.33 | 4,811.02 |
| 35300 | Бэлэн бүтээгдэхүүн | 12,926.40 | 53,820.00 |
| **35400** | **Хангамжийн материал** | **620,212.58** | **558,232.09** |
| 35410 | Бичиг хэргийн материал | 200.00 | 200.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 34,581.60 | 34,990.15 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 27,791.40 | 29,836.40 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 557,639.58 | 493,205.54 |
| 35600 | Мал амьтад | 36,028.84 | 28,208.84 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,239,223.26** | **1,574,746.06** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **1,239,223.26** | **1,574,746.06** |
| **39200** | **Биет хөрөнгө** | **1,219,843.72** | **1,556,383.39** |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,284,759.34 | 1,450,569.36 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -432,302.27 | -454,329.55 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 221,607.02 | 319,273.68 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -204,834.72 | -210,073.29 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж(компьютер) | 432,379.26 | 590,845.99 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -222,169.67 | -273,930.63 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 75,234.68 | 76,664.68 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -55,248.93 | -58,104.18 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 146,424.91 | 146,424.91 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -28,972.99 | -33,924.69 |
| 39217 | Ном | 2,967.10 | 2,967.10 |
| **39300** | **Биет бус хөрөнгө** | **19,379.54** | **18,362.67** |
| 39301 | Програм хангамж | 750.00 | 750.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -662.50 | -750.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 29,501.00 | 29,501.00 |
| 39304 | Хуримтлагдсан элэгдэл | -10,208.96 | -11,138.33 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **2,463,450.54** | **3,567,212.75** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **7,373.44** | **107,305.64** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | **7,373.44** | **107,305.64** |
| **41300** | **Өглөг** | **7,373.44** | **107,305.64** |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 0.00 | 345.56 |

| | | | |
|---|---|---|---|
| 41330 | Татаас, санхүүжилт, шилжүүлгийн өглөг | 0.00 | 106,960.07 |
| **41360** | **Бусад өглөг** | **7,373.44** | **0.00** |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 7,366.89 | 0.00 |
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | 6.54 | 0.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **2,456,077.11** | **3,459,907.11** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | **2,456,077.11** | **3,459,907.11** |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал | 531,874.80 | 531,874.80 |
| 511002 | Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө | 531,874.80 | 531,874.80 |
| **51200** | **Хуримтлагдсан үр дүн** | **1,378,531.77** | **2,382,361.78** |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 1,262,670.62 | 1,378,531.77 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 115,861.15 | 1,003,830.01 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 545,670.54 | 545,670.54 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **2,463,450.54** | **3,567,212.75** |

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан (мянган төгрөгөөр)

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **2,897,631.55** | **3,312,003.28** |
| **11** | **ТАТВАРЫН ОРЛОГО** | **526,885.86** | **1,216,381.18** |
| **110** | **Орлогын албан татвар** | **261,301.25** | **775,652.38** |
| **1100** | **Хувь хүний орлогын албан татвар** | **261,301.25** | **775,652.38** |
| 110001 | Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрх | 186,082.26 | 305,642.74 |
| 110002 | Үйл ажиллагааны орлого | 19,640.88 | 404,280.48 |
| 110003 | Хөрөнгийн орлого | 45,140.82 | 48,946.30 |
| 110004 | Хөрөнгө борлуулсны орлого | 10,437.30 | 16,782.86 |
| **113** | **Хөрөнгийн албан татвар** | **42,950.14** | **73,644.86** |
| 113001 | Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар | 9,490.66 | 11,360.46 |
| 113002 | Бууны албан татвар | 2,070.00 | 4,050.00 |
| 113004 | Малд ногдуулах албан татвар | 31,389.48 | 58,234.40 |
| **118** | **Бусад татвар, төлбөр, хураамж** | **222,634.47** | **367,083.94** |
| **1180** | **Бусад нийтлэг төлбөр, хураамж** | **18,196.40** | **19,957.17** |
| 118001 | Улсын тэмдэгтийн хураамж | 1,167.00 | 625.17 |
| 118006 | Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр | 300.00 | 1,500.00 |
| 118009 | Хог хаягдлын үйлчилгээний хураамж | 16,729.40 | 17,832.00 |
| **1181** | **Газрын төлбөр** | **65,654.53** | **96,272.77** |
| 118101 | Газрын төлбөр | 63,722.53 | 96,247.19 |
| 118102 | Дуудлага худалдаа | 1,932.00 | 25.58 |
| **1182** | **Байгалийн нөөц ашигласны төлбөр** | **131,708.97** | **250,836.00** |
| 118202 | Ан амьтны нөөц ашигласны төлбөр | 131,708.97 | 250,836.00 |
| **1183** | **Бусад татвар** | **7,074.57** | **18.00** |
| 118301 | Бусад татвар | 7,074.57 | 18.00 |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **298,752.49** | **758,101.50** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **298,752.49** | **758,101.50** |
| 120003 | Торгуулийн орлого | 89,821.00 | 91,950.00 |
| **120004** | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | **91,563.03** | **119,337.60** |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 28,388.03 | 84,337.60 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 63,175.00 | 35,000.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 52,433.23 | 395,235.42 |

| | | | |
|---|---|---|---|
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | 64,935.24 | 151,578.49 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **2,071,993.21** | **1,337,520.59** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **109,667.75** | **166,961.69** |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 109,667.75 | 67,498.45 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 0.00 | 99,463.25 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **1,962,325.45** | **1,170,558.90** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 1,180,834.10 | 0.00 |
| 132003 | Төвлөрүүлэх шилжүүлэг /орон нутгийн төсөвт байгууллага улсад төвлөрүүлэх орлого/ | 41,021.15 | 0.00 |
| 132006 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт / аймгаас авсан санхүүгийн дэмжлэг/ | 369,955.70 | 591,648.70 |
| 132007 | Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих | 370,514.50 | 578,910.20 |
| **II** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **2,781,770.40** | **2,304,137.07** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **2,781,770.40** | **2,304,137.07** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,451,901.90** | **2,300,884.28** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **460,281.11** | **743,916.04** |
| 210101 | Үндсэн цалин | 334,286.72 | 450,438.73 |
| 210102 | Нэмэгдэл | 107,899.88 | 265,211.12 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 8,209.00 | 14,515.00 |
| 210104 | Урамшуулал | 9,885.51 | 13,751.20 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **57,831.11** | **92,782.41** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 39,372.47 | 63,094.39 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,632.05 | 7,368.86 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,692.44 | 3,975.19 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 903.76 | 3,639.32 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 9,230.39 | 14,704.66 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **43,050.81** | **354,681.22** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 10,518.14 | 39,152.91 |
| 210302 | Түлш, халаалт | 32,504.67 | 312,520.94 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 28.00 | 3,007.37 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **150,818.75** | **69,788.56** |
| 210401 | Бичиг хэрэг | 21,254.85 | 7,286.80 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 51,094.00 | 33,574.81 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 827.60 | 1,479.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 480.00 | 315.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 15,734.70 | 26,165.17 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,140.00 | 967.79 |
| 210409 | Бараа материал шилжүүлсний зардал | 58,287.60 | 0.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **3,958.00** | **3,000.00** |
| 210502 | Хоол, хүнс | 3,958.00 | 3,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **21,455.00** | **52,396.70** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 15,020.00 | 0.00 |
| 210604 | Урсгал засвар | 6,435.00 | 52,396.70 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **7,360.00** | **7,552.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 7,360.00 | 7,552.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **490,496.19** | **773,933.72** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 482,917.58 | 769,492.05 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 0.00 | 500.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 881.20 | 200.93 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 2,313.59 | 176.74 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 136.25 | 0.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 3,764.00 | 3,564.00 |
| 210807 | Газрын төлбөр | 483.57 | 0.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **216,650.93** | **202,833.62** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 113,032.38 | 111,490.50 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 8,652.25 | 3,492.50 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 94,966.30 | 87,850.62 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **1,329,868.50** | **3,252.79** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **8,550.00** | **3,252.79** |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 4,045.00 | 1,000.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 0.00 | 946.54 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 4,505.00 | 1,306.25 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | **1,321,318.50** | **0.00** |
| 213401 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт төсөвт байгууллага | 1,180,834.10 | 0.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 41,021.15 | 0.00 |
| 213405 | Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | 99,463.25 | 0.00 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)** | **115,861.15** | **1,007,866.21** |
| **V** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | **0.00** | **4,036.20** |
| 225002 | Найдваргүй авлагын алдагдал | 0.00 | 4,036.20 |
| **VI** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)** | **115,861.15** | **1,003,830.01** |

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан (мянган төгрөгөөр)

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| 1 | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **531,874.80** | **574,270.54** | **1,176,470.62** | **2,282,615.95** |
| 2 | **Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт** | **0.00** | **0.00** | **86,200.00** | **86,200.00** |
| 3 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **531,874.80** | **574,270.54** | **1,262,670.62** | **2,368,815.95** |
| 4 | **Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт** | **0.00** | **-28,600.00** | **0.00** | **-28,600.00** |
| 9 | **Тайлант үеийн үр дүн** | **0.00** | **0.00** | **115,861.15** | **115,861.15** |
| 10 | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **531,874.80** | **545,670.54** | **1,378,531.77** | **2,456,077.11** |
| 11 | **2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **531,874.80** | **545,670.54** | **1,378,531.77** | **2,456,077.11** |
| 13 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **531,874.80** | **545,670.54** | **1,378,531.77** | **2,456,077.11** |
| 19 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | 1,003,830.01 | 1,003,830.01 |
| 20 | **2024 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл** | **531,874.80** | **545,670.54** | **2,382,361.78** | **3,459,907.11** |

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан (мянган төгрөгөөр)

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)** | **2,801,977.48** | **2,784,437.95** |
| **11** | **ТАТВАРЫН ОРЛОГО** | **526,885.86** | **1,216,381.18** |
| **110** | **Орлогын албан татвар** | **261,301.25** | **775,652.38** |
| **1100** | **Хувь хүний орлогын албан татвар** | **261,301.25** | **775,652.38** |
| 110001 | Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрх | 186,082.26 | 305,642.74 |
| 110002 | Үйл ажиллагааны орлого | 19,640.88 | 404,280.48 |
| 110003 | Хөрөнгийн орлого | 45,140.82 | 48,946.30 |
| 110004 | Хөрөнгө борлуулсны орлого | 10,437.30 | 16,782.86 |
| **113** | **Хөрөнгийн албан татвар** | **42,950.14** | **73,644.86** |
| 113001 | Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар | 9,490.66 | 11,360.46 |
| 113002 | Бууны албан татвар | 2,070.00 | 4,050.00 |
| 113004 | Малд ногдуулах албан татвар | 31,389.48 | 58,234.40 |
| **118** | **Бусад татвар, төлбөр, хураамж** | **222,634.47** | **367,083.94** |
| **1180** | **Бусад нийтлэг төлбөр, хураамж** | **18,196.40** | **19,957.17** |
| 118001 | Улсын тэмдэгтийн хураамж | 1,167.00 | 625.17 |
| 118006 | Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр | 300.00 | 1,500.00 |
| 118009 | Хог хаягдлын үйлчилгээний хураамж | 16,729.40 | 17,832.00 |
| **1181** | **Газрын төлбөр** | **65,654.53** | **96,272.77** |
| 118101 | Газрын төлбөр | 63,722.53 | 96,247.19 |
| 118102 | Дуудлага худалдаа | 1,932.00 | 25.58 |
| **1182** | **Байгалийн нөөц ашигласны төлбөр** | **131,708.97** | **250,836.00** |
| 118202 | Ан амьтны нөөц ашигласны төлбөр | 131,708.97 | 250,836.00 |
| **1183** | **Бусад татвар** | **7,074.57** | **18.00** |
| 118301 | Бусад татвар | 7,074.57 | 18.00 |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **203,098.42** | **230,536.17** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **203,098.42** | **230,536.17** |
| 120003 | Торгуулийн орлого | 89,821.00 | 91,950.00 |
| **120004** | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | **113,277.42** | **138,586.17** |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 50,102.42 | 103,586.17 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 63,175.00 | 35,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **2,071,993.21** | **1,337,520.59** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **109,667.75** | **166,961.69** |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 109,667.75 | 67,498.45 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 0.00 | 99,463.25 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **1,962,325.45** | **1,170,558.90** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 1,180,834.10 | 0.00 |
| 132003 | Төвлөрүүлэх шилжүүлэг /орон нутгийн төсөвт байгууллага улсад төвлөрүүлэх орлого/ | 41,021.15 | 0.00 |
| 132006 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт / аймгаас авсан санхүүгийн дэмжлэг/ | 369,955.70 | 591,648.70 |
| 132007 | Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих | 370,514.50 | 578,910.20 |
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **2,377,915.62** | **1,561,736.63** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **2,377,915.62** | **1,561,736.63** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,048,047.12** | **1,511,839.91** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **460,494.20** | **746,904.01** |

| | | | |
|---|---|---|---|
| 210101 | Үндсэн цалин | 291,427.59 | 429,207.36 |
| 210102 | Нэмэгдэл | 135,703.08 | 284,876.32 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 8,809.00 | 13,668.29 |
| 210104 | Урамшуулал | 11,690.60 | 19,152.05 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 12,863.92 | 0.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **58,741.90** | **90,100.10** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 39,215.20 | 61,268.10 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,399.50 | 7,208.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,387.20 | 3,604.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 976.30 | 3,604.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 9,763.70 | 14,416.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **259,180.41** | **354,681.22** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 38,186.52 | 39,152.91 |
| 210302 | Түлш, халаалт | 217,686.97 | 312,520.94 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 3,306.93 | 3,007.37 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **59,459.09** | **70,111.56** |
| 210401 | Бичиг хэрэг | 8,628.85 | 7,175.80 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 27,737.54 | 34,310.66 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,639.60 | 1,389.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 480.00 | 290.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 17,833.10 | 26,106.10 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,140.00 | 840.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **2,500.00** | **0.00** |
| 210502 | Хоол, хүнс | 2,500.00 | 0.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **37,262.40** | **52,396.70** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 10,000.00 | 0.00 |
| 210604 | Урсгал засвар | 27,262.40 | 52,396.70 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **7,332.00** | **7,552.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 7,332.00 | 7,552.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **32,078.84** | **15,540.67** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 24,503.23 | 11,099.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 0.00 | 500.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 881.20 | 200.93 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 2,310.59 | 77.24 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 136.25 | 99.50 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 3,764.00 | 3,564.00 |
| 210807 | Газрын төлбөр | 483.57 | 0.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **130,998.28** | **174,553.66** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 120,110.53 | 171,061.16 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 10,887.75 | 3,492.50 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **1,329,868.50** | **49,896.72** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **8,550.00** | **49,896.72** |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 3,600.00 | 1,000.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 0.00 | 47,590.47 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 4,950.00 | 1,306.25 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | **1,321,318.50** | **0.00** |

| | | | |
|---|---|---|---|
| 213401 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт төсөвт байгууллага | 1,180,834.10 | 0.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 41,021.15 | 0.00 |
| 213405 | Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | 99,463.25 | 0.00 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)** | **424,061.86** | **1,222,701.32** |
| **V** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)** | **654,940.26** | **546,308.35** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **654,940.26** | **546,308.35** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | **654,940.26** | **546,308.35** |
| 220001 | Барилга байгууламж | 591,927.73 | 518,170.35 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 63,012.53 | 28,138.00 |
| **VI** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)** | **-654,940.26** | **-546,308.35** |
| **VIII** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)** | **-230,878.39** | **676,392.97** |
| 101 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 575,273.91 | 344,395.51 |
| 20 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 344,395.51 | 1,020,788.48 |

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан (мянган төгрөгөөр)

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **2,660,061.80** | **2,048,058.96** | **612,002.84** | **77.0** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,651,927.70** | **1,529,888.61** | **122,039.09** | **92.6** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,649,527.70** | **1,527,582.36** | **121,945.34** | **92.6** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **749,679.10** | **746,904.01** | **2,775.09** | **99.6** |
| 210101 | Үндсэн цалин | 441,349.70 | 429,207.36 | 12,142.34 | 97.2 |
| 210102 | Нэмэгдэл | 283,319.50 | 284,876.32 | -1,556.82 | 100.5 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 0.00 | 13,668.29 | -13,668.29 | |
| 210104 | Урамшуулал | 25,009.90 | 19,152.05 | 5,857.85 | 76.6 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **90,100.10** | **90,100.10** | **0.00** | **100.0** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 61,268.10 | 61,268.10 | 0.00 | 100.0 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 7,208.00 | 7,208.00 | 0.00 | 100.0 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,604.00 | 3,604.00 | 0.00 | 100.0 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3,604.00 | 3,604.00 | 0.00 | 100.0 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 14,416.00 | 14,416.00 | 0.00 | 100.0 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **361,961.60** | **354,681.22** | **7,280.38** | **98.0** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 42,908.20 | 39,152.91 | 3,755.29 | 91.2 |
| 210302 | Түлш, халаалт | 314,553.40 | 312,520.94 | 2,032.46 | 99.4 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 4,500.00 | 3,007.37 | 1,492.63 | 66.8 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **70,768.70** | **70,419.56** | **349.14** | **99.5** |
| 210401 | Бичиг хэрэг | 7,188.90 | 7,175.80 | 13.10 | 99.8 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 34,323.30 | 34,310.66 | 12.64 | 100.0 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,768.50 | 1,697.00 | 71.50 | 96.0 |
| 210404 | Ном, хэвлэл | 300.00 | 290.00 | 10.00 | 96.7 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 26,348.00 | 26,106.10 | 241.90 | 99.1 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 840.00 | 840.00 | 0.00 | 100.0 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **73,950.00** | **73,826.70** | **123.30** | **99.8** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 21,500.00 | 21,430.00 | 70.00 | 99.7 |
| 210604 | Урсгал засвар | 52,450.00 | 52,396.70 | 53.30 | 99.9 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **7,645.20** | **7,552.00** | **93.20** | **98.8** |
| 210702 | Дотоод албан томилолт | 7,645.20 | 7,552.00 | 93.20 | 98.8 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **15,462.00** | **14,940.67** | **521.33** | **96.6** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 10,500.00 | 10,499.00 | 1.00 | 100.0 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 500.00 | 500.00 | 0.00 | 100.0 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 280.00 | 200.93 | 79.08 | 71.8 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 118.00 | 77.24 | 40.76 | 65.5 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 200.00 | 99.50 | 100.50 | 49.8 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 3,564.00 | 3,564.00 | 0.00 | 100.0 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 300.00 | 0.00 | 300.00 | 0.0 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **279,961.00** | **169,158.10** | **110,802.90** | **60.4** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 276,461.00 | 165,665.60 | 110,795.40 | 59.9 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 3,500.00 | 3,492.50 | 7.50 | 99.8 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **2,400.00** | **2,306.25** | **93.75** | **96.1** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **2,400.00** | **2,306.25** | **93.75** | **96.1** |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 1,000.00 | 1,000.00 | 0.00 | 100.0 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,400.00 | 1,306.25 | 93.75 | 93.3 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **1,008,134.10** | **518,170.35** | **489,963.75** | **51.4** |
| 220001 | Барилга байгууламж | 1,008,134.10 | 518,170.35 | 489,963.75 | 51.4 |
| **III** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **2,660,061.80** | **2,265,667.28** | **394,394.52** | **85.2** |
| **31** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **613,498.40** | **0.00** | **613,498.40** | **0.0** |
| 310004 | Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих | 613,498.40 | 0.00 | 613,498.40 | 0.0 |
| **32** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **1,722,412.60** | **2,127,081.11** | **-404,668.51** | **123.5** |
| 320001 | Орон нутгийн төсвөөс | 1,722,412.60 | 1,548,170.91 | 174,241.69 | 89.9 |
| 320002 | Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих | 0.00 | 578,910.20 | -578,910.20 | |
| **35** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | **314,150.80** | **138,586.17** | **175,564.63** | **44.1** |
| 350001 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 30,000.00 | 103,586.17 | -73,586.17 | 345.3 |
| 350002 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 40,100.10 | 35,000.00 | 5,100.10 | 87.3 |
| 350003 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 244,050.70 | 0.00 | 244,050.70 | 0.0 |
| **36** | **ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ** | **10,000.00** | **0.00** | **10,000.00** | **0.0** |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 360001 | Тусламжийн эх үүсвэрээс санхүүжих | 10,000.00 | 0.00 | 10,000.00 | 0.0 |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 0.00 | 251,288.32 | -251,288.32 | |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 0.00 | 468,896.63 | -468,896.63 | |
| | Ажиллагсадын тоо | 31.00 | 30.00 | 1.00 | 96.8 |
| | Удирдах ажилтны тоо | 9.00 | 9.00 | 0.00 | 100.0 |
| | Гүйцэтгэх ажилтны тоо | 11.00 | 10.00 | 1.00 | 90.9 |
| | Үйлчлэх ажилтны тоо | 9.00 | 9.00 | 0.00 | 100.0 |
| | Гэрээт ажилтны тоо | 2.00 | 2.00 | 0.00 | 100.0 |

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн тайлан (мянган төгрөгөөр)

| Код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **166,961.69** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **166,961.69** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **12,395.56** |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **1,000.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **11,395.56** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 11,395.56 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **154,566.14** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **47,590.47** |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 47,590.47 |
| **2133** | **Олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **106,975.67** |
| 213405 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | 106,975.67 |
| **I** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **166,961.69** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **166,961.69** |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 67,498.45 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 99,463.25 |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Баянхонгор аймгийн Бөмбөгөр сум нь "Орчин үеийн тэргүүний дэвшилтэт технологи нэвтэрсэн өндөр мэргэжилтэй, чадварлаг боловсон хүчний чадварт түшиглэн төрийн үйлчилгээг үзүүлэх, Монгол Улсын төр засгийн хууль, тогтоомжийг сумын хэмжээнд сурталчлах, төрийн үйлчилгээг ард түмэнд хөнгөн шуурхай хүргэх" гэсэн эрхэм зорилго дэвшүүлэн дараах зорилтыг тавин ажиллажээ. Үүнд:

- Ардчилсан, шударга ёс , хүний эрх ,эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийн хангах
- Сумынхаа хөгжилд иргэн бүр хувь нэмрээ оруулах, манлайлах нөхцөлийн бүрдүүлэх
- Зах зээлийн эдийн засагт суурилсан хөгжлийн бодлого, стратегийн хэрэгжүүлэх оновчтой бүтцийг бий болгох

- Хөрөнгө нөөцийг бүрдүүлэх, тэргүүлэх чиглэл, эрэлт хэрэгцээнд суурилан хуваарилах, түүнийг ил тод байлгах, зарцуулалтыг хянан гүйцэтгэлийн үр дүнг үнэлж дахин төлөвлөх
- Бүх талын түншлэлд суурилах
- Нөхцөл байдлын өөрчлөлтөд уян хатан зохцох чадамжтай болох
- Бүх шатанд хуулиа дээдлэх, хариуцлага хүлээх чадвартай, ил тод байх

### 3.2 БАЙГУУЛЛАГА, ТҮҮНИЙ ОРЧИН БА ДОТООД ХЯНАЛТ

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн байна.

Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь Бөмбөгөр сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын 2024 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Бөмбөгөр сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл суурьар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь 2018 онд аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсээс гаргасан “Төсөвт байгууллагуудын нягтлан бодох бүртгэлийн бодлогын жишиг баримт бичиг”-ийг үйл ажиллагаандаа ашиглаж, санхүүгийн тайлан бэлтгэхдээ мөрдөж ажиллаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа НБББ нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГО, ТОЛИЛУУЛГАД ГАРСАН ӨӨРЧЛӨЛТҮҮД

Бөмбөгөр сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн

захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам"-ийн дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна. Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,103,762.2 мянган төгрөгөөр буюу 44.8 хувиар өссөн байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

**3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга** (мянган төгрөгөөр)

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 1,224,227.3 | 1,992,466.7 | 768,239.4 |
| Мөнгөн хөрөнгө | 344,395.5 | 1,020,788.5 | 676,393.0 |
| Авлага | 203,206.6 | 326,606.3 | 123,399.7 |
| Бараа материал | 676,625.1 | 645,071.9 | -31,553.2 |
| ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 1,239,223.3 | 1,574,746.1 | 335,522.8 |
| Үндсэн хөрөнгө | 2,193,623.3 | 2,616,996.7 | 423,373.4 |
| Хуримтлагдсан элэгдэл | -954,400.0 | -1,042,250.7 | -87,850.7 |
| **Нийт хөрөнгө** | **2,463,450.5** | **3,567,212.7** | **1,103,762.2** |
| Өр төлбөр | 7,373.4 | 107,305.6 | 99,932.2 |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 2,456,077.1 | 3,459,907.1 | 1,003,830.0 |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **2,463,450.5** | **3,567,212.7** | **1,103,762.2** |

### 3.5.1. Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 344,395.5 мянган төгрөг байсан бөгөөд эцсийн үлдэгдэл 1,020,788.5 мянган төгрөг болж 676,393.0 мянган төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт № 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл* */мянган төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) | Дунд эзлэх хувь |
|---|---|---|---|---|
| Касст байгаа бэлэн мөнгө | 0 | 0 | 0 | 0 |
| Төрийн санд байгаа бэлэн мөнгө | 344,395.5 | 1,020,788.5 | 676,393.0 | 100% |
| Орон нутгийн ерөнхий орлого | 93,107.2 | 551,891.8 | 458,784.6 | 54.1% |
| Орон нутгийн хөгжлийн сан | 194,050.7 | 426,636.2 | 232,585.5 | 41.8% |
| Хоршоо хөгжүүлэх сан | 57,237.6 | 42,260.5 | -14,977.1 | 4.1% |
| Замд яваа мөнгөн хөрөнгө | 0 | 0 | 0 | |
| Хадгаламж | 0 | 0 | 0 | |
| **Дүн** | **344,395.5** | **1,020,788.5** | 676,393.0 | **100%** |

*Эх сурвалж: Бөмбөгөр сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 1,020,788.5 мянган төгрөг нь орон нутгийн Ерөнхий орлогын дансны үлдэгдэл 551,891.8 мянга, Орон нутгийн хөгжлийн сангийн дансанд 426,636.2 мянга, Сум хөгжүүлэх сангийн дансанд 42,260.5 мянган төгрөг тус тус байршиж байна.

### 3.5.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 203,206.6 мянган төгрөг байсан ба эцсийн үлдэгдэл 326,606.3 мянган төгрөг болж 123,399.7 мянган төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт № 3. Авлагын үлдэгдэл* */ мянган төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|---|---|---|---|
| Татаас санхүүжилтын авлага | - | 106,960.1 | 106,960.1 |
| Зээлийн хүүгийн авлага | 14,737.1 | 15,993.0 | 1,255.9 |

| | | | |
|---|---|---|---|
| Байгууллагаас авах авлага | 58,187.8 | 58,912.2 | 724.4 |
| Хувь хүмүүст олгосон зээл | 130,281.7 | 144,741.0 | 14,459.3 |
| **Дүн** | 203,206.6 | 326,606.3 | 123,399.7 |

Эх сурвалж: *Бөмбөгөр сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Нийт авлагын 49.2 хувь буюу 160,734.1 мянган төгрөг нь хоршоо хөгжүүлэх сангийн сангийн авлага, 32.7 хувь буюу 106,960.1 мянган төгрөг нь татаас санхүүжилтийн авлага, 18.0 хувь буюу 58,912.2 мянган төгрөг нь байгууллагаас авах авлага байна.

*Хүснэгт № 4. Авлагын үлдэгдэл байгууллагаар* */мянган төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) | Дүнд эзлэх хувь |
|---|---|---|---|---|
| Засаг даргын Тамгын газар | 57,732.0 | 164,625.5 | 106,893.5 | 50.4 |
| ИТХ | 455.8 | 1,246.7 | 790.9 | 0.4 |
| СХС | 145,018.8 | 160,734.1 | 15,715.3 | 49.2 |
| **НИЙТ ДҮН** | **203,206.6** | **326,606.3** | **123,399.7** | **100.00** |

Эх сурвалж: *Бөмбөгөр сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Тайлант онд өмнөх оноос хоршоо хөгжүүлэх сангийн авлага 15,715.3 мянга, ИТХ-ын авлага 790.9 мянга, ЗДТГ-ын авлага 106,893.5 мянган төгрөгөөр тус тус өссөн байна.

### 3.5.3 Бараа материал

Бараа материалын эхний үлдэгдэл 676,625.1 мянган төгрөг байсан ба эцсийн үлдэгдэл 645,071.9 мянган төгрөг болж, 31,553.2 мянган төгрөгөөр буурсан байна.

*Хүснэгт № 5. Бараа материалын үлдэгдэл /мянган төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|---|---|---|---|
| Тусгай зориулалтын материал | 7,457.3 | 4,811.0 | -2,646.3 |
| Бэлэн бүтээгдэхүүн | 12,926.4 | 53,820.0 | 40,893.6 |
| Бичиг хэргийн материал | 200.0 | 200.0 | 0.0 |
| Аж ахуйн материал | 34,581.6 | 34,990.2 | 408.6 |
| Сэлбэг хэрэгсэл | 27,791.4 | 29,836.4 | 2,045.0 |
| Бусад хангамжийн материал | 557,639.6 | 493,205.5 | -64,434.1 |
| Мал амьтад | 36,028.8 | 28,208.8 | -7,820.0 |
| **Дүн** | **676,625.1** | **645,071.9** | **-31,553.2** |

Эх сурвалж: *Бөмбөгөр сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Бараа материалын дансны үлдэгдэл 645,071.9 мянган төгрөг болж 31,553.2 мянган төгрөгөөр буурсан байна.

*Хүснэгт № 6. Бараа материалын үлдэгдэл байгууллагаар /мянган төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) | Дүнд эзлэх хувь |
|---|---|---|---|---|
| ИТХ | 8,977.0 | 15,307.5 | 6,330.5 | 2.4 |
| ЗДТГ | 110,008.5 | 136,558.9 | 26,550.4 | 21.2 |
| ОНХС | 557,639.6 | 493,205.5 | (64,434.1) | 76.5 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| **НИЙТ ДҮН** | **676,625.1** | **645,071.9** | **-31,553.2** | **100.0** |

*Эх сурвалж: Бөмбөгөр сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Тайлант онд нийт нэмэгдсэн 476,687.0 мянган төгрөгийн бараа материалаас 325,108.5 мянган төгрөгийн бараа материалыг төсвийн хөрөнгөөр, 1,700.3 мянган төгрөгийн бараа материалыг хандиваар, 149,878.2 мянган төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй шилжүүлэн авсан байна. Мөн нийт хасагдсан 506,240.2 мянган төгрөгийн бараа материалаас 506,240.2 мянган төгрөгийг зарцуулсан байна.

*Хүснэгт № 7. Бараа материалын орлого, зарлагын төрөл /мянган төгрөг/*

| **Нэмэгдсэн** | **476,687.0** | **Хасагдсан** | **506,240.2** |
|---|---|---|---|
| Худалдан авсан | 325,108.5 | Худалдсан, зарцуулсан | 506,240.2 |
| Хандиваар | 1,700.3 | шилжүүлсэн | |
| Шилжүүлсэн авсан | 149,878.2 | | |

*Эх сурвалж: Бөмбөгөр сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

### 3.5.7 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 2,193,623.3 мянган төгрөг байсан ба эцсийн үлдэгдэл 2,616,996.7 мянган төгрөг болж 423,373.4 мянган төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт № 8. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /мянган төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) | Дүнд эзлэх хувь |
|---|---|---|---|---|
| БИЕТ ХӨРӨНГӨ | 2,163,372.3 | 2,586,745.7 | 423,373.4 | 98.8 |
| Барилга байгууламж, орон сууц | 1,284,759.3 | 1,450,569.3 | 165,810.0 | 55.4 |
| Тээврийн хэрэгсэл | 221,607.0 | 319,273.7 | 97,666.7 | 12.2 |
| Машин тоног төхөөрөмж | 432,379.3 | 590,846.0 | 158,466.7 | 22.6 |
| Тавилга эд хогшил | 75,234.7 | 76,664.7 | 1,430.0 | 2.9 |
| Номын фонд | 2,967.1 | 2,967.1 | 0.0 | 0.1 |
| Бусад үндсэн хөрөнгө | 146,424.9 | 146,424.9 | 0.0 | 5.6 |
| **БИЕТ БУС ХӨРӨНГӨ** | 30,251.0 | 30,251.0 | 0.0 | 1.2 |
| Программ хангамж | 750.0 | 750.0 | 0.0 | 0.0 |
| Бусад биет бус хөрөнгө | 29,501.0 | 29,501.0 | 0.0 | 1.1 |
| **НИЙТ ДҮН** | 2,193,623.3 | 2,616,996.7 | 423,373.4 | 100.0 |

*Эх сурвалж: Бөмбөгөр сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Үндсэн хөрөнгийн үлдэгдэлд 98.2 хувь ЗДТГ, 1.8 хувь нь ИТХ-ийн хөрөнгө байна.

*Хүснэгт № 9. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл байгууллагаар /мянган төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) | Дүнд эзлэх хувь |
|---|---|---|---|---|
| ИТХ | 36,002.7 | 48,209.7 | 12,207.0 | 1.8 |
| ЗДТГ | 2,157,620.6 | 2,568,787.0 | 411,166.4 | 98.2 |
| **НИЙТ ДҮН** | **2,193,623.3** | **2,616,996.7** | **423,373.4** | **100.0** |

*Эх сурвалж: Бөмбөгөр сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Тайлант онд үндсэн хөрөнгө 423,373.4 мянган төгрөгөөр хөрөнгө нэмэгдсэн нь ЗДТГ нь төсвийн хөрөнгөөр 19,308.0 мянга, ИТХ 8,830.0 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авсан, ЗДТГ хандиваар ирсэн 252,266.7 мянган төгрөгийн хөрөнгийг

бүртгэсэн, ЗДТГ 139,591.8 мянга, ИТХ 3,377.0 мянган төгрөгийн шилжүүлэн авсан нь голлох нөлөө үзүүлсэн байна.

*Хүснэгт 10. Үндсэн хөрөнгийн орлого, зарлагын төрөл /мянган төгрөг/*

| Нэмэгдсэн | **423,373.4** | Хасагдсан | **0** |
|---|---|---|---|
| Худалдан авсан | 28,138.0 | Шилжүүлсэн | 0 |
| Хандиваар авсан | 252,266.7 | Акталсан | 0 |
| Шилжүүлэн авсан | 142,968.8 | | |

*Эх сурвалж: Бөмбөгөр сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

### 3.5.8 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 7,373.4 мянган төгрөг байсан ба эцсийн үлдэгдэл 107,305.6 мянган төгрөг болж 7,027.9 мянган төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт 11. Нийт өр төлбөрийн үлдэгдэл /мянган төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) | Дүнд эзлэх хувь |
|---|---|---|---|---|
| БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР ДҮН | 7,373.4 | 107,305.6 | -7,027.9 | 0.3 |
| Ажилчидтай холбогдсон өглөг | - | 345.5 | 345.5 | 0.3 |
| Татаас, санхүүжилт, шилжүүлгийн өглөг | - | 106,960.1 | 106,960.1 | 99.7 |
| Байгууллагад төлөх өглөг | 7,366.9 | - | (7,366.9) | - |
| Хувь хүмүүст өгөх өглөг | 6.5 | - | (6.5) | - |
| **Дүн** | 7,373.4 | 107,305.6 | (7,027.9) | 0.3 |

*Эх сурвалж: Бөмбөгөр сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Богино хугацаат өр төлбөр нь 107,305.6 мянган төгрөгийн үлдэгдэлтэй бөгөөд ЗДТГ 311.7 мянга, ИТХ 33.8 мянга, ОНХС 106,960.1 мянга, орон нутгийн ерөнхий орлого 106,960.1 мянган төгрөгийн үлдэгдэл өглөг нь ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансны үлдэгдэл төвлөрүүлснээс үүссэн байна.

*Хүснэгт № 12. Нийт өр төлбөрийн үлдэгдэл байгууллагаар /мянган төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) | Дүнд эзлэх хувь |
|---|---|---|---|---|
| ИТХ | | 33.8 | 33.8 | 0.0 |
| ЗДТГ | 6.5 | 311.7 | 305.2 | 0.3 |
| ОНХС | 7,366.9 | | (7,366.9) | - |
| Орон нутгийн ерөнхий орлого | | 106,960.1 | 106,960.1 | 99.7 |
| ДҮН | 7,373.4 | 107,305.6 | 99,932.2 | 100.0 |

*Эх сурвалж: Бөмбөгөр сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

### 3.5.9 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 2,456,077.1 мянган төгрөг байсан ба эцсийн үлдэгдэл 3,459,907.1 мянган төгрөг болж, 1,003,830.0 мянган төгрөгөөр төгрөгөөр өссөн байна.

**ХҮСНЭГТ № 13. ЗАСГИЙН ГАЗРЫН ХУВЬ ОРОЛЦОО /МЯНГАН ТӨГРӨГ/**

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өссөн+ Буурсан - | Дүнд эзлэх хувь |
|---|---|---|---|---|
| Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 531,874.8 | 531,874.8 | - | 15.4 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| Өмч: - төрийн | | | - | - |
| **Хуримтлагдсан үр дүн** | 1,378,531.8 | 2,382,361.8 | 1,003,830.0 | 68.9 |
| Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 545,670.5 | 545,670.5 | - | 15.8 |
| **Дүн** | 2,456,077.1 | 3,459,907.1 | 1,003,830.0 | 100.0 |

Эх сурвалж: Бөмбөгөр сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 1,003,830.0 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.7 Орлогын данс

Сумын ИТХ-ын 2023 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 15/04 дүгээр тогтоолоор сумын төсвийн татварын орлогыг 637,963.9 мянга, хүү торгуулийн орлогыг 60,000.0 мянга, нийт 697,963.9 мянган төгрөгөөр баталсан ба сумын ИТХ-ын 2024 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн 18/10 дугаар тогтоолоор 339,800.0 мянган төгрөгийн орлогыг нэмж тодотгон нийт 997,763.9 мянган төгрөгөөр баталсан байна.

*Хүснэгт №14. Төвлөрүүлэх орлого /мянган төгрөг/*

| Орлогын төрөл | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|
| Нийт орлого ба тусламжийн дүн | 1,731,362.4 | 2,025,827.6 | 294,465.15 | 117.01 |
| Татварын орлого | 977,683.9 | 1,216,381.3 | 238,697.28 | 124.4 |
| Орлогын албан татвар | 497,000.0 | 775,652.4 | 278,652.40 | 156.1 |
| ХХОАТ | 497,000.0 | 775,652.4 | 278,652.40 | 156.1 |
| ЦХТА рлого /суутган/ | 240,000.0 | 305,642.7 | 65,642.70 | 127.4 |
| Үйл ажиллагааны орлого | 218,200.0 | 404,280.5 | 186,080.50 | 185.3 |
| Хөрөнгийн орлого | 34,800.0 | 48,946.3 | 14,146.30 | 140.7 |
| Хөрөнгө борлуулсны орлого | 4,000.0 | 16,782.9 | 12,782.90 | 419.6 |
| Хөрөнгийн албан татвар | 166,939.9 | 73,644.9 | -93,295.00 | 44.1 |
| Үл хөдлөх хөрөнгийн албан татвар | 12,200.0 | 11,360.5 | -839.50 | 93.1 |
| Галт зэвсгийн албан татвар | 3,255.0 | 4,050.0 | 795.00 | 124.4 |
| Малд ногдуулах албан татвар | 151,484.9 | 58,234.4 | -93,250.50 | 38.4 |
| Бусад татвар, төлбөр, хураамж | 14,448.0 | 19,957.2 | 5,509.20 | 138.1 |
| Бусад нийтлэг төлбөр, хураамж | 14,448.0 | 19,957.2 | 5,509.20 | 138.1 |
| Улсын тэмдэгтийн хураамж | 3,000.0 | 625.2 | -2,374.80 | 20.8 |
| ТТАМАТөлбөр | 1,500.0 | 1,500.0 | 0.00 | 100.0 |
| Хог хаягдлын үйлчилгээний хураамж | 9,948.0 | 17,832.0 | 7,884.00 | 179.3 |
| Газрын төлбөр | 100,000.0 | 96,272.8 | -3,727.20 | 96.3 |
| Газрын төлбөр | 100,000.0 | 96,247.2 | -3,752.80 | 96.2 |
| Газрын дуудлага худалдааны орлого | - | 25.6 | 25.6 | |
| Байгалийн нөөц ашигласны төлбөр | 199,296.0 | 250,836.0 | 51,540.00 | 125.9 |
| Ан амьтны нөөц ашигласны төлбөр | 199,296.0 | 250,836.0 | 51,540.00 | 125.9 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| Бусад татвар | - | 18.0 | 18.0 | |
| Татварын бус орлого | 753,678.4 | 716,218.4 | -37,460.00 | 753,678.4 |
| Нийтлэг татварын бус орлого | 140,180.0 | 137,308.2 | -2,871.80 | 140,180.0 |
| Торгуулийн орлого | 60,000.0 | 91,950.0 | 31,950.00 | 60,000.0 |
| Төсөвт байгууллагын өөрийн орлого | 70,100.0 | 45,358.2 | -24,741.80 | 70,100.0 |
| Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 30,000.0 | 10,358.2 | -19,641.80 | 30,000.0 |
| Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 40,100.0 | 35,000.0 | -5,100.00 | 40,100.0 |
| Газрын тосны орлого | 80.0 | - | | |
| Тусламжийн орлого /гадаад/ | 10,000.0 | - | | |
| Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг | 613,498.4 | 578,910.2 | -34,588.20 | 94.4 |
| Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого | 613,498.4 | 578,910.2 | -34,588.20 | 94.4 |

*Эх сурвалж: Бөмбөгөр сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Сумын төсөвт төвлөрөх татварын болон татварын бус орлогыг 117.0 хувь буюу 297,465.2 мянган төгрөгөөр давуулан биелүүлсэн байна. Орлогын нэр төрлөөр авч үзвэл цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого 65,642.7 мянга, үйл ажиллагааны орлого 186,080.5 мянга, хөрөнгийн орлого 14,146.3 мянга, хөрөнгө борлуулсны орлого 12,782.9 мянга, галт зэвсгийн албан татвар 795.0 мянга, хог хаягдлын хураамж 7,884.0 мянга, газрын дуудлага худалдааны орлогыг 25.6 мянга, ан амьтны нөөц ашигласны төлбөрийг 51,540.0 мянга, хүү, торгуулийн орлогыг 31,950.0 мянган төгрөгөөр тус тус давуулан биелүүлсэн байна.

Харин үл хөдлөх хөрөнгийн албан татварыг 839.5 мянга, малд ногдох албан татвар 93,250.5 мянга, улсын тэмдэгтийн хураамжийг 2,374.8 мянга, газрын төлбөрийн орлогыг 3,752.8 мянган төгрөгөөр тус тус дутуу төвлөрсөн байна.

Төсөвт байгууллагын өөрийн орлогод сумын Засаг даргын Тамгын газар 1,000.0 мянган төгрөгийн орлогыг оруулахаар төлөвлөсөн боловч орлого ороогүй байна.

Сум хөгжүүлэх сангийн зээл, хүүгийн төлөлтөөр тайлант онд 30,000.0 мянган төгрөгийг оруулахаар баталснаас 24,975.0 мянга, Орон нутгийн хөгжлийн сангийн өвс, тэжээлийн орлогоос 39,100.1 мянган төгрөг оруулахаар төлөвлөснөөс 113,611.2 мянган төгрөгийн орлого төвлөрсөн байна.

### 3.8 Зардлын данс

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 70105, 70106, 70503, 73,402, 71602, 71702, 71801, 71802, 72101 гэсэн кодтой 9 хөтөлбөрт зориулан 2,660,061.8 мянган төгрөгийн төсөв батлагдаж 2,048,059.1 мянган төгрөгийг гүйцэтгэлээр зарцуулснаас 1,529,888.6 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулж 518,170.4 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулсан байна.

*Хүснэгт №15.Төсвийн гүйцэтгэл /мянган төгрөг/*

| Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|
| **Нийт зарлага ба зээлийн дүн** | **2,660,061.8** | **2,048,059.1** | **612,002.7** | **77.0** |
| **70105 Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага** | **189,119.0** | **188,501.2** | **617.8** | **99.7** |
| 80101 Үндсэн үйл ажиллагааны зардал | 188,119.0 | 187,501.2 | 617.8 | **99.7** |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулал | 1,000.0 | 1,000.0 | 0.0 | 100.0 |
| **70106 Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага** | **1,045,344.9** | **968,086.1** | **77,258.8** | **92.6** |
| 80101 Үндсэн үйл ажиллагааны зардал | 710,465.2 | 705,487.5 | 4,977.7 | 99.3 |
| 80106 Баг хорооны үйл ажиллагааны зардал | 131,970.7 | 130,743.7 | 1,227.0 | 99.1 |
| 80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулал | 1,000.0 | 931.3 | 68.7 | 93.1 |
| 81701 Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх зардал | 110,000.0 | 39,260.0 | 70,740.0 | 35.7 |
| 81102 Орон нутгийн нөөц хөрөнгө | 66,461.0 | 66,455.5 | 5.5 | 100.0 |
| 82212 хур хог хаягдал, орчны бохирдол | 25,448.0 | 25,208.1 | 239.9 | 99.1 |
| **70503 Орон нутгийн зорилтот орон оруулалт** | **1,008,134.1** | **518,170.4** | **489,963.7** | **154.3** |
| 80904 Нийгмийн зориулалттай барилга | 243,150.8 | 194,344.3 | 48,806.5 | 79.9 |
| 83401 ОНХС-Итгэлцүүрээр тооцох | 452,469.4 | 317,447.6 | 135,021.8 | 70.2 |
| 73402 ОНХС-хайгуулийн тусгай зөвшөөрлийн төлбөр | 3,210.0 | 0.0 | 3,210.0 | 0.0 |
| 73403 ОНХС-ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр | 100,431.0 | 0.0 | 100,431.0 | 0.0 |
| 83405 ОНХС Малын тоо толгойн албан татвар | 151,484.9 | 6,378.5 | 145,106.4 | 4.2 |
| 83406 ОНХС -бусад | 57,388.0 | 0.0 | 57,388.0 | 0.0 |
| **71602 Эмнэлгийн тусламж үйлчилгээ** | **72,650.0** | **72,459.0** | **191.0** | **99.7** |
| 80112 Нийтлэг үйлчилгээ | 72,650.0 | 72,459.0 | 191.0 | 99.7 |
| **71702 Соёл урлаг** | **28,739.2** | **25,872.1** | **2,867.1** | **90.0** |
| 80112 Нийтлэг үйлчилгээ | 28,739.2 | 25,872.1 | 2,867.1 | 90.0 |
| **71801 Сургуулийн өмнөх боловсрол** | **75,086.7** | **74,988.0** | **98.7** | **99.9** |
| 80112 Нийтлэг үйлчилгээ | 75,086.7 | 74,988.0 | 98.7 | 99.9 |
| **71802 Ерөнхий боловсрол** | **160,987.9** | **160,030.2** | **957.7** | **99.4** |
| 80112 Нийтлэг үйлчилгээ | 160,987.9 | 160,030.2 | 957.7 | 99.4 |
| **72101 Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих** | **80,000.0** | **39,952.1** | **40,047.9** | **49.9** |
| 82611 Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих | 80,000.0 | 39,952.1 | **40,047.9** | **49.9** |

*Эх сурвалж: Бөмбөгөр сумын Засаг даргын нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан*

## 3.9 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.9.1 Төсвийн төлөвлөлт

Тус төвлөрүүлэн захирагчийн харьяаны 5 төсвийн байгууллага төсвийн төслийг бэлтгэж, аймгийн СТСХ-т хүргүүлсэн бөгөөд сумын ИТХ-ын 2023 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн хуралдаанаар 15/04 дүгээр тогтоолоор нийт 2,316,451.1 мянган төгрөгийг баталсан ба сумын ИТХ-ын 2024 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн 19/10 дугаар тогтоолоор 343,610.7 мянган төгрөгийг нэмж тодотгосон байна.

*Хүснэгт №16. Төсвийн төлөвлөлт байгууллагаар /мянган төгрөг/*

| Орлогын төрөл | Төсвийн төсөл | Анх батлагдсан төсөв | Зөрүү |
|---|---|---|---|
| Иргэдийн төлөөлөгчдийн хурал | 123,914.4 | 159,071.2 | 35,156.8 |
| Засаг даргын Тамгын газар | 848,131.8 | 873,486.3 | 25,354.5 |
| Сургууль | 135,070.6 | 189,733.2 | 54,662.6 |

| | | | |
|---|---|---|---|
| Цэцэрлэг | 72,429.1 | 49,626.7 | -22,802.4 |
| Эрүүл мэндийн төв | 43,803.4 | 63,679.3 | 19,875.9 |
| Соёлын төв | 30,679.8 | 32,083.2 | 1,403.4 |
| Сум хөгжүүлэх сан | 80,000 | 80,000.0 | 0.0 |
| Орон нутгийн хөгжлийн сан | 888,492.0 | 868,771.2 | -19,720.8 |
| **Нийт дүн** | 2,222,521.1 | 2,316,451.1 | 93,930.0 |

*Эх сурвалж: Бөмбөгөр сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

### 3.9.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 8 хөтөлбөрийн арга хэмжээний зардалд сумын ИТХ-ын 2023 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн хуралдаанаар 15/04 дүгээр тогтоолоор нийт 2,316,451.1 мянган төгрөгийг баталсан ба сумын ИТХ-ын 2024 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн 19/10 дугаар тогтоолоор 343,610.7 мянган төгрөгөөр өсгөж 2,660,061.8 мянган төгрөг болжээ.

Нийт зардлын 613,498.4 мянган төгрөгийг орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох санхүүжилтээс, 591,648.7 мянган төгрөгийг санхүүгийн дэмжлэгээс, 977,763.9 мянган төгрөгийг орон нутгийн орлогоос, 60,000.0 мянган төгрөгийг хүү, торгуулийн орлогоос, 1,000.0 мянган төгрөгийг төсөвт байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогоос, 30,000.0 мянган төгрөгийг хоршоо хөгжүүлэх сангийн эргэн төлөлтийн орлогоос, 39,100.0 мянган төгрөгийг ОНХС-ийн өвс, тэжээлийн эргэн төлөлтөөс, 10,000.0 мянган төгрөгийн хандив тусламжийн орлогоос, 337,050.7 мянган төгрөгийг урьд оны үлдэгдлээс тус тус санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр аймгаас авсан санхүүгийн дэмжлэг 591,648.7 мянга, орон нутгийн орлогоос 956,522.2 мянга, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох санхүүжилтээс 578,910.2 мянга, ХХС-ийн зээлийн эргэн төлөлтөөс 24,975.0 мянга, ОНХС-аас 113,611.2 мянга, нийт 2,265,667.3 мянган төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлэн 80,991.2 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

*Хүснэгт №17. Төсвийн гүйцэтгэл байгууллагаар /мянган төгрөг/*

| Байгууллагын нэр | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь | ОН |
|---|---|---|---|---|---|
| ЗДТГ | 1,045,344.9 | 968,086.0 | 77,258.9 | 92.6 | 76,258.9 |
| ИТХ | 189,119.0 | 188,501.2 | 617.8 | 99.7 | 617.8 |
| Соёлын төв | 28,739.2 | 25,872.1 | 2,867.1 | 90.0 | 2,867.1 |
| Сум хөгжүүлэх сан | 80,000.0 | 39,952.1 | 40,047.9 | 49.9 | |
| Сургууль | 160,987.9 | 160,030.2 | 957.7 | 99.4 | 957.7 |
| Цэцэрлэг | 75,086.7 | 74,988.0 | 98.7 | 99.9 | 98.7 |
| ЭМТ | 72,650.0 | 72,459.0 | 191.0 | 99.7 | 191.0 |
| ОНХС | 1,008,134.1 | 518,170.4 | 489,963.7 | 51.4 | |
| Нийт дүн | 2,660,061.8 | 2,048,059.0 | 612,002.8 | 77.0 | 80,991.2 |

*Эх сурвалж: Бөмбөгөр сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,048,059.0 мянган төгрөг буюу 77.0 хувьтай байгаа нь урсгал зардлыг ЗДТГ-ын 76,258.9 мянга, ИТХ-ын 617.8 мянга, тогтмол зардлыг соёлын төв 2,867.1 мянга, сургууль 957.7 мянга, цэцэрлэг 98.7 мянга, эрүүл мэндийн төвийн 191.0 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэн нь голлох нөлөөг үзүүлж байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.9.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд дээд шатны төсвийн захирагчаас хуваарилсан 166,961.7 мянга, нийт 166,961.7 мянган төгрөгийн санхүүжилтийг олгож, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 1,000.0 мянга, бараа үйлчилгээний бусад зардал 11,395.6 мянга, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэгт 47,590.4 мянган төгрөгийг тус тус зарцуулж 106,975.7 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

*Хүснэгт 18. Нэмэлт санхүүжилтийн дансны судалгаа /мянган төгрөгөөр/*

| Үзүүлэлт | ИТХ | ЗДТГ | НИЙТ |
|---|---|---|---|
| **НИЙТ ОРЛОГО** | 10,481.9 | 156,479.8 | 166,961.7 |
| Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 10,481.9 | 156,479.8 | 166,961.7 |
| **НИЙТ ЗАРЛАГА** | 10,466.3 | 49,519.7 | 59,986.0 |
| Бараа үйлчилгээний бусад зардал | | 11,395.6 | 11,395.6 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,000.0 | | 1,000.0 |
| Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 9,466.3 | 38,124.1 | 47,590.4 |
| **Төсөвт төвлөрүүлсэн** | 15.6 | 106,960.1 | 106,975.7 |

*Эх сурвалж: Бөмбөгөр сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж заасны дагуу Бөмбөгөр сумын Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгохтой холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Н.Батчимэг гүйцэтгэж аудитын менежер М.Алтантуяа, Дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар үе шатны хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Бөмбөгөр сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийлгэх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 144 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

Бөмбөгөр сумын Засаг даргын 1 дүгээр гарын үсгийг Засаг дарга Н.Пүрэвсүрэн, 2 дугаар гарын үсгийг санхүү албаны дарга Б.Нарангэрэл нар зурж байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны нийт батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 65 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны батлагдсан төсөв 2,660,061.8 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 39,901.0 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлын төлөвлөлтийн материаллаг байдлын 65 хувиар буюу 25,936.0 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт болон *Төрийн хэмнэлтийн тухай хуулийн* хэрэгжилтийг шалгаж үр дүнг баримтжуулсан.

### 4.4 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 145 мэдээллээс 142 мэдээллийг хугацаанд нь, 3 мэдээллийг мэдээллийн хугацаа болоогүй байна.

*Хүснэгт 19. Шилэн дансны мэдээлэл*

| д/д | Хугацаа | Төрөл | Мэдээлвэл зохих/удаа | Хугацаанд оруулсан | Хугацаа хоцроосон | Хугацаа болоогүй |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Бүтэн жил | 13 | 13 | 10 | | 3 |
| 2 | Хагас жил | 1 | 1 | 1 | | |
| 3 | Сар бүр | 6 | 72 | 72 | | |
| 4 | Тухай бүр | 5 | 59 | 59 | | |
| | Нийт | 24 | 145 | 142 | | 3 |

### 4.5 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайланд онд Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөж ажиллахыг бүх шатны төсөв захирагчид даалгасан. Уг хуулийн хэрэгжилтийг Бөмбөгөр сумын Засаг даргын харьяа төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар шалгахад зөрчил илрээгүй.

### 4.6 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөрчил илрээгүй байна.

### 4.7 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй.

### 4.8 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд сумын орон нутгийн нөөц хөрөнгөнд 66,461.0 төгрөгөөр баталж 66,455.5 мянган төгрөгийг зарцуулж 5.5 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Тайлант онд Засаг даргын нөөц хөрөнгөтэй холбоотой зөрчил дутагдал илрээгүй байна.

### 4.9 Аудитын гол асуудал

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Бөмбөгөр сумын Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн 2024 оны жилийн эцсийн хэрэгжилтийг 87.6 хувьтай дүгнэсэн байна.

Тайлант онд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээнд зориулан нийт 2,660,061.8 мянган төгрөгийг зарцуулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр нийт 2,048,059.0 мянган төгрөгийг зарцуулж 77.0 хувийн биелэлттэй байна.

Сумын ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Бөмбөгөр сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяалагдах 2 төсвийн байгууллага, 2 тусгай сан, нийт 4 байгууллагын санхүүгийн тайлан 4 улсын төсвийн байгууллагын тогтмол зардал нэгтгэгдсэн байна

Төрийн аудитын байгууллагаас Бөмбөгөр сумын Засаг даргын харьяа 4 байгууллагын санхүүгийн тайланг түүвэр аудитад хамруулан санхүүгийн аудитыг гүйцэтгэсэн байна.

*Хүснэгт №20. Төсвийн шууд захирагчийн аудитын дүн*

| Байгууллагын нэр | Байгууллагын тоо | | | | Аудитын санал дүгнэлтийн төрөл | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Гүйцэтгэсэн | | | Үүнээс | | | |
| | Хамрагдвал зохих | Хамрагдсан | Бие дааж дүгнэлт гаргасан | Түүвэрт хамруулсан | Бүгд | Зөрчилгүй | Хязгаарлалттай | Сөрөг | Санал дүгнэлт өгөхөөс татгалзсан |
| **ЗДТГ** | 1 | | 1 | | | 1 | | | |
| **ИТХурал** | 1 | 1 | | 1 | | | | | |
| ОНХС | 1 | 1 | | 1 | | | | | |
| **СХС** | 1 | 1 | | 1 | | | | | |
| **НИЙТ ДҮН** | **4** | **4** | **1** | **3** | | **1** | **0** | **0** | **0** |

*Эх сурвалж: Төрийн аудитын байгууллагын зөрчлийн нэгтгэл*

Сумын ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 337,726.7 мянган төгрөгийн 8 алдаа, зөрчил илэрснээс 297,472.1 мянган төгрөгийн 3 алдааг санхүүгийн тайланд залруулж, 14,944.6 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт, 25,310.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 2 албан шаардлага хүргүүлж ажилласан байна. Хүснэгтээр харуулбал:

*Хүснэгт №21. Төсвийн шууд захирагчийн алдаа зөрчлийн дүн* */мянган төгрөгөөр/*

| Байгууллагын нэр | Нийт алдаа зөрчлийн дүн | | Үүнээс: Залруулагдаагүй алдаа, зөрчлийн шийдвэрлэлт | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Залруулга | | Тогтоосон төлбөрийн акт | | Өгсөн албан шаардлага | | Өгсөн зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Санхүүгийн тайлангийн зөрчил | | | | | | | | | | |
| ИТХурал | 1 | 345.3 | 1 | 345.3 | | | | | | |
| ЗДТГ | 4 | 301,798.9 | 2 | 297,126.8 | 1 | 172.1 | 1 | 4,500.0 | | |
| ОНХСан | 1 | 20,000.0 | | | | | 1 | 20,000.0 | | |
| СХС | 2 | 15,582.5 | | | 1 | 14,772.5 | 1 | 810.0 | | |
| СТА зөрчлийн дүн | 8 | 337,726.7 | 3 | 297,472.1 | 2 | 14,944.6 | 3 | 25,310.0 | - | - |

*Эх сурвалж: Төрийн аудитын байгууллагын зөрчлийн нэгтгэсэн*

Төсвийн шууд захирагчдын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн залруулагдаагүй зөрчлийг санхүүгийн тайлангийн болон нийцлийн аудиттай холбоотой асуудал гэж ангилан үзсэн бөгөөд санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой 40,254.8 мянган төгрөгийн 5 зөрчил илэрч, нийцлийн аудиттай холбоотой зөрчил илрээгүй байна.

Хүснэгт 22. Төсвийн шууд захирагчийн зөрчлийн дүн /мянган төгрөгөөр/

| 8 | Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн /мянган төгрөг/ | Алдаа, зөрчлийн шийдвэрлэлт. | Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны | |
|---|---|---|---|---|---|
| | | | | Албан тушаал | Овог нэр |
| **А** | 2 | 3 | 4 | 5 | 6 |
| Засаг даргын Тамгын газар | | 4,672.1 | | | |
| 1 | Тэтгэвэрт гарсан албан хаагчийн цалинг НДШ-ийн мэдээнд 2024 оны 6 дугаар сард 717.1 мянган төгрөгөөр илүү мэдээлснээс 172.1 мянган төгрөгийг илүү шилжүүлсэн байна. | 172.1 | Төлбөрийн акт тогтоосон | Төсвийн захирагч, нягтлан бодогч | Ц.Мөнхжаргал С.Баттулга |
| 2 | Дурсамж принт" ХХК-д 2024 оны 03 дугаар сарын 06-ны өдөр 2021 онд үйлдвэрлэсэн өмнөх онд өглөгөөр тусгаагүй "Өрхтэй харилцах дэвтрийн үнэ"-д 4,500.0 мянган төгрөгийг бараа үйлчилгээний бусад зардлаас шилжүүлсэн байна. | 4,500.0 | Албан шаардлага өгсөн | Төсвийн захирагч, нягтлан бодогч | Ц.Мөнхжаргал С.Баттулга |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| Хоршоо хөгжүүлэх сан | | 15,582.5 | | | |
| 1 | Тайлант оны жилийн эцсийн байдлаар 8 зээлдэгчийн 144,740.9 мянган төгрөгийн зээлийн үлдэгдэл байгаагаас 3 зээлдэгчийн 14,772.5 мянган төгрөгийн зээлийн эргэн төлөлт төлөгдөөгүй хугацаа хэтэрсэн байна. | 14,772.5 | Төлбөрийн акт тогтоосон | Төсвийн захирагч, нягтлан бодогч | Н.Пүрэвсүрэн Ж.Сэржмядаг |
| 2 | Шүүхийн захирамж гарсан хугацаа хэтэрсэн 1 зээлдэгчийн 810.0 мянган төгрөгийн зээлийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад шилжүүлж төлүүлэх арга хэмжээ аваагүй байна. | 810.0 | Албан шаардлага өгсөн | Төсвийн захирагч, нягтлан бодогч | Н.Пүрэвсүрэн Ж.Сэржмядаг |
| Орон нутгийн хөгжлийн сан | | 20,000.0 | | | |
| 1 | Иргэдийн санал аваагүй 20,000.0 мянган төгрөгийн төсөл арга хэмжээг санхүүжүүлсэн байна. | 20,000.0 | Албан шаардлага өгсөн | Төсвийн захирагч, нягтлан бодогч | Н.Пүрэвсүрэн Ж.Сэржмядаг |
| | Нийт дүн | 40,254.6 | | | |

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 93,250.5 мянган төгрөгийн 2 зөрчил илэрснээс, 93,250.5 мянган төгрөгийн 2 албан шаардлага хүргүүлсэн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс хэтрээгүй тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өглөө.

### 2.2 Албан шаардлага

2.2.1. Малд ногдох албан татвар 151,484.9 мянган төгрөг оруулахаар төлөвлөсөн ба 58,234.4 мянган төгрөгийг төвлөрүүлж 93,250.5 мянган төгрөг дутуу төвлөрсөн байна.

Энэ нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.1 дэх "Татвар төлөгч нь холбогдох татварын хуулиар төлбөл зохих татварын ногдлоо өөрөө тодорхойлж, хуулиар тогтоосон хугацаанд төсөвт төлнө", Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь "Тухайн татварын жилд албан татвар ногдуулах малын тоо толгойг Статистикийн тухай хуульд заасны дагуу хийгдсэн өмнөх жилийн мал тооллогын дүнд үндэслэн тодорхойлно", 7 дугаар зүйлийн 7.1 дэх "Албан татвар төлөгч энэ хуулийн дагуу ногдуулсан албан татварыг тэнцүү хоёр хуваан тухайн жилийн 7 дугаар сарын 15, 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор өөрийн өмчилж байгаа малын тоо толгой тоологдож бүртгэгдсэн сум, дүүргийн төсөвт төлнө" гэсэн заалтыг зөрчин, санхүүгийн тайлангийн "Нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Сумын төсөвт төвлөрөх татварын орлогыг бодитой төлөвлөж, албан татварыг тайлант хугацаанд нь төсөвт бүрэн төвлөрүүлэх албан шаардлагыг хүргүүлэв.

2.2.2. Төсвийн төвлөрүүлэн захирагчийн өмнөх оны төсвийн гүйцэтгэл болон санхүүгийн нэгтгэсэн тайланг ирүүлэхдээ төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр 54.5 дахь хэсэгт заасан хөтөлбөр арга хэмжээ, хүрсэн дүнгийн талаарх бүрэлдэхүүн хэсгээр ирүүлээгүй зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь "Төсвийн гүйцэтгэлийн тайлан нь дараах бүрэлдэхүүн хэсэгтэй байна", 54.5.4 дэх "Хөтөлбөр,

арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүн, түүний танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Сумын ТТЗ-ийн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасан бүрэлдэхүүн гаргаж ирүүлэх, зөрчлийг арилгах албан шаардлагыг хүргүүлэв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ:

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

(мянган төгрөг)

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Санхүүгийн тайланд орлогыг нэмэгдүүлэн тусгасан | 1 | 5,800.0 | - | - | 1 | 5,800.0 | 1 | 5,800.0 | - | - |
| Дүн | 1 | 5,800.0 | - | - | 1 | 5,800.0 | 1 | 5,800.0 | - | - |

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(мянган төгрөг)

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Малд ногдох албан татвар 151,484.9 мянган төгрөг оруулахаар төлөвлөсөн ба 58,234.4 мянган төгрөгийг төвлөрүүлж 93,250.5 мянган төгрөг дутуу төвлөрсөн байна. | 1 | 93,250.0 | - | - | 1 | 93,250.0 | - | - |
| Төсвийн төвлөрүүлэн захирагчийн өмнөх оны төсвийн гүйцэтгэл болон санхүүгийн нэгтгэсэн тайланг ирүүлэхдээ төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр 54.5 дахь хэсэгт заасан хөтөлбөр арга хэмжээ, хүрсэн дүнгийн талаарх бүрэлдэхүүн хэсгээр ирүүлээгүй | 1 | 0 | - | - | 1 | 0 | - | - |
| Дүн | 2 | 93,250.0 | - | - | 2 | 93,250.0 | - | - |

-----------oOo-----------